

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:

“ЛИТИУМ СЕНЧУРИ” ХХК

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

**БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗӨВЛӨХ
“ГОВЬ-ЭКО” ХХК**

**ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ЛИТИУМ СЕНЧУРИ”
ХХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “УРТЫН ЦАГААН ЧУЛУУТ ЛИТИЙН ОРДЫГ
ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/Регистрийн дугаар: 5745721/



УЛААНБААТАР ХОТ

2025 ОН

“ЛИТИУМ СЕНЧУРИ” ХХК

“ЛИТИУМ СЕНЧУРИ” ХХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “УРТЫН ЦАГААН ЧУЛУУТ ЛИТИЙН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/Регистрийн дугаар: 5745721/

/Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-022910/

Төлөвлөгөөтэй танилцсан:

“ЛИТИУМ СЕНЧУРИ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.САРАНТУЯА



Төлөвлөгөө боловсруулсан:

“ГОВЬ-ЭКО” ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН
Н.НАСАНХИШИГ



УЛААНБААТАР ХОТ
2025 ОН

АГУУЛГА

ОРШИЛ.....	5
БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	7
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл	7
1.2 Төслийн байршил.....	8
1.2 Төслийн бүтээгдэхүүний тухай	10
1.3 Ил уурхайн уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө.....	11
1.4 Баяжуулах үйлдвэр	13
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ НУТАГ ДЭВСГЭРИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ	15
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	17
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	21
4.1 Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилго, зорилт.....	21
4.2 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	22
4.3 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	35
4.4 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	38
ДҮГНЭЛТ.....	40

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн мэдээлэл.....	8
Хүснэгт 2. Техник - Эдийн засгийн үндсэн үзүүлэлт.....	11
Хүснэгт 3. Ил уурхайн олборлолтын ажлын календарьчилсан төлөвлөгөө	12
Хүснэгт 4. Олборлолтонд өртөх талбай, шимт хөрс хуулалтын ажлын календарчилсан төлөвлөгөө	12
Хүснэгт 5. Болзошгүй нөлөөлөл байгалийн хам бүрдэлтэй уялдах нь	20
Хүснэгт 6. БОМТөлөвлөгөөний зардлын задаргаа /мян.төг/	22
Хүснэгт 7. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал /мян.төг/	23
Хүснэгт 8. Болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээ	25
Хүснэгт 9. Нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, зардал	27
Хүснэгт 10. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	29
Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	33
Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн хүрээнд хэрэгжүүлэх ажил.....	34
Хүснэгт 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хуваарь	38
Хүснэгт 14. БОМТ-ний биелэлтийн тайланг хэлэлцүүлэх хуваарь	39

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.Төслийн талбайн ерөнхий байршлын зураг	9
Зураг 2. Төслийн талбайн фото зураг	9
Зураг 3. “Уртын цагаан чулуут орд”-н Литийн хүдэр баяжуулах үйлдвэрийн технологийн ерөнхий схем.....	13
Зураг 4 .Баяжуулах үйлдвэрийн талбайн төлөвлөлт	14
Зураг 5. Гал унтраах хэрэгсэл	30
Зураг 6. Аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээ.....	31
Зураг 7. Төслийн талбай дахь мониторингийн цэг	36

ОРШИЛ

Монгол улсад Ховор металл болох литийн хүдэр олборлох, хүдрийг боловсруулан баяжмал үйлдэрлэж нэмүү өртөг шингээн экспортлодог анхдагч уурхай болох зорилт тавин ажиллаж байна. Төсөл эдийн засгийн хувьд өгөөжтэй байхаас илүү байгаль орчинд ээлтэй, Монгол улсын экспортын бараа бүтээгдэхүүний тоог нэмж, шинэ технологи ашиглан уурхайг хөгжүүлэх зорилготой.

Литийн ордууд нь эдийн засаг, эрчим хүчний салбарт ихээхэн ач холбогдолтой. Лити нь цахилгаан батерей, утасгүй төхөөрөмжүүд, сэргээгдэх эрчим хүчний технологи зэрэг олон салбарт хэрэглэгддэг.

Байгаль орчны үнэлгээ, зөвлөх үйлчилгээний “Говь-Эко” ХХК болон “Литиум сенчури” ХХК-ийн хооронд байгуулсан гэрээний дагуу “Уртын цагаан чулуут литийн ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /БОМТ/-г БОНХСайдын 2019 оны 10 дугаар 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” болон ерөнхий үнэлгий дүгнэлт болон бусад холбогдох дүрэм, журам, стандартад нийцүүлэн гүйцэтгэв.

Байгаль орчны менежмент төлөвлөгөөний үндэслэл:

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлагдах төсөл хэрэгжүүлэх, дараа дараагийн жилүүдэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухайн хуулийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр заасан.

Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй төслийн Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний ажлыг 2024 онд хийж гүйцэтгэсэн байна.

Бид бүхэн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал” болон ерөнхий үнэлгээний дүгнэлтийг удирдлага болголоо.

Төсөл хэрэгжүүлэгч нь төрийн бодлого, хууль журмыг сахин биелүүлж төслөөс учрах аливаа сөрөг нөлөөллийг Монгол улсын хууль журам, стандартын

шаардлагад нийцүүлэн хамгийн бага түвшинд, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байх үүрэгтэй.

Зөвлөх үйлчилгээний ажлын зорилго, ажлын төлөвлөгөө, үр дүн:

Ажлын зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төслийн талбай, түүний орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. Энэхүү төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

- Ажиллагсад бүх байгаль орчныг хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон байхын зэрэгцээ тэдэнд биелүүлэхэд нь туслах бэлтгэл сургалт, ур чадвартай мэргэжилтэнтэй болсон байна.
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан тооцож, байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, орчны төлөв байдлыг сайжруулах, хэвийн нөхцөлийг хадгалж хамгаална.
- Орон нутгийн удирдлага, хяналтын байгууллага, иргэдтэй байгаль орчныг хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний санал, хүсэлтийг хүлээн авч, хамтран ажиллана.

Байгаль орчны асуудлаарх төрийн захиргаанаас өгсөн санал зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллана.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тухайн төслийн БОМТ-тэй танилцан баталж, төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгох ба жил бүрийн хэрэгжилтийн тайланг хянаж, дараа жилийн төлөвлөгөөг батлах замаар уг төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянана. Мөн БОМТ-ний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, БОУАӨЯ болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй ба тэдгээрт холбогдох мэдээлэл ил тод болгох, тодорхой хуваарийн дагуу хяналт хийх боломжийг бүрдүүлэх нь төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг болно.

Бүрэлдэхүүн хэсэг: БОМТ-г доорх үндсэн 2 бүрэлдэхүүн хэсгүүдэд ангилан авч үзэв. Үүнд:

- а) Байгаль орчны менежмент төлөвлөгөө: Төслийн шууд ба шууд бус сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах үйл ажиллагааг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
- б) Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр: Төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэрхэн үр дүнтэй болсон эсэх, шаардлагатай үед нэмэлт арга хэмжээ авах зорилгоор төслийн үргэлжлэх бүхий л хугацааны турш хэрэгжүүлэх орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Литиум сенчури” ХХК нь Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших “344” гэх нэртэй газарт “Уртын цагаан чулуут” литийн ордын MV-022910 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2025 оны 3-р сарын 12-ны өдрийн 183 тоот шийдвэрээр батлуулсан.

Хайгуулын ажлаар ордын нөөцийг бодитой /В/ зэргээр 1,019.9 мян.тн хүдэрт 10,975 тн лити, боломжтой /С/ зэргээр 728.1 мян.тн хүдэрт 4,529.5 тн лити, нийт бодитой болон боломжтой зэргээр /В+С/ 1,748.0 мян.тн хүдэрт 15,504.5 тн литийн исэл агуулагдана гэж тооцоолсон байна.

Литийн ордууд нь эдийн засаг, эрчим хүчний салбарт ихээхэн ач холбогдолтой. Лити нь цахилгаан батерей, утасгүй төхөөрөмжүүд, сэргээгдэх эрчим хүчний технологи зэрэг олон салбарт хэрэглэгддэг.

Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл: Лити нь салхи, нарны эрчим хүчийг хадгалах батерей үйлдвэрлэхэд чухал үүрэгтэй. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг тогтвортой ашиглахад литийн батерейнууд чухал хүчин зүйл болж байна.

Эдийн засгийн өсөлт: Литийн олборлолт болон боловсруулах салбар нь орон нутгийн эдийн засагт чухал үр нөлөө үзүүлдэг. Эдгээр ордууд нь ажлын байр, татварын орлого, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлдэг.

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл


№	Улсын нэр	Монгол улс
1	Төслийн нэр	“Уртын цагаан чулуут” литийн ордыг ил аргаар ашиглах төсөл
2	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	“Литиум сенчури” ХХК
3	Төсөл хэрэгжүүлэгчийн улсын бүртгэлийн, регистрийн дугаар	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9019097907 Регистрийн дугаар: 5646804
4	Төсөл хэрэгжүүлэх газар	Төв аймаг, Эрдэнэ сум, 344 гэх нэртэй газар
5	Төслийн зорилго	Батлагдсан Эрдэнэ баялагийн нөөцийг эдийн засгийн эргэлтэнд оруулах, Монгол улсад Ховор металл болох литийн хүдэр олборлох, хүдрийг боловсруулан баяжмал үйлдэрлэж нэмүү өртөг шингээн экспортлодог анхдагч уурхай болох зорилт тавин ажиллаж байна. Төсөл эдийн засгийн хувьд өгөөжтэй байхаас илүү байгал орчинд ээлтэй, Монгол улсын экспортын бараа бүтээгдэхүүний тоог нэмж шинэ худалдааны гарц боломжыг нээж, шинэ технологи нутагшуулсан уурхай болох

		зорилготой болно.
6	Төслийн хүчин чадал	Хөрс хуулалт - 1250.34 мян.м ³ Хүдэр олборлолт - 350 мян.тн Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал: 300'000 тн/жил Хөрс хуулалтын дундаж коэффициент - 3.57 м ³ /тн
7	Цахилгаан хангамж	Уурхайн цахилгаан хангамжийг Улааны цементийн үйлдвэрийн өмнө байрлах “7-р зөрлөг” дэд өртөөнд Багахангайн 110/35 кВ-ийн дэд өртөөнөөс ирсэн 35 кВ-ийн цахилгаан дамжуулах агаарын шугамын төгсгөлөөс төмөр бетон тулгууртай, 150 мм ² хөндлөн огтлолтой хөнгөн цагаан утас бүхий 24 км цахилгаан дамжуулах агаарын шугам татаж хангана.
8	Усан хангамж	Төслийн үйл ажиллагаанд шаардагдах усны хэрэглээг эхний жилд “Өгөөж их орд” ХХК-ийн төслийн талбайд гаргасан 2ш гүний худгаас ус зөөвөрлөн ашиглахаар төлөвлөж байгаа бол дараагийн жилүүдэд “Литиум сенчури” ХХК нь өөрийн талбайд 3ш гүний худаг гарган ажиллахаар төлөвлөж байна.
9	Зам харилцаа	Төсөл хэрэгжих талбай нь Улаанбаатар хотоос 75км-т Налайх дүүргээс баруун урагш 30 км-ийн зайд байрлана.
10	Харилцах утас, факс	91921414
11	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Очир центр 603 тоот

Хүснэгт 1. Төслийн мэдээлэл

1.2 Төслийн байршил

Төсөл хэрэгжих талбай нь Улаанбаатар хотоос 75км-т Налайх дүүргээс баруун урагш 30 км-ийн зайд Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт “344” гэх нэртэй газар 332 га талбайд хэрэгжинэ. Төсөл хэрэгжих талбайн байршлыг дараах зурагт харуулав.



Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг



Зураг 2. Төслийн талбайн фото зураг

1.2 Төслийн бүтээгдэхүүний тухай

Таванбогд Фүүдс” компаний “KFC” олон улсын сүлжээ ресторан нь: Дараах нэр төрөлийн үйлчилгээг үзүүлж байна.Үүнд

№	Үзүүлэлтүүд	Тодорхойлолтууд
1	Аж ахуйн нэгжийн нэр	“Литиум Сенчури” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар	711002059
3	Уурхайн нэр	Уртын Цагаан Чулуут
4	Ордын нэр ба тусгай зөвшөөрлийн дугаар	“Уртын Цагаан Чулуут” Литийн орд MV-022910
5	Батлагдсан геологийн нөөц, Li ₂ O	B = 10,975.0 тн C = 4,529.5 тн B+C = 15,504.5 тн
7	Ил уурхайн хүрээн дэх геологийн нөөц	B+C = 1,648,035.0 тн (Хүдрээр)
8	Ил уурхайн хүрээн дэх үйлдвэрлэлийн нөөц	B+C = 1,659,897.0 тн (Хүдрээр)
9	Ашиглах арга ба хугацаа	Ил уурхайн аргаар 5 жил
10	Ашиглалтын систем	Авто тээвэртэй гадаад овоолготой
11	Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд	Өрмийн машин - Hanfa HF120Y Экскаватор - Hyundai R210LC, R290LC Автосамосвалл - Howo 3257N Утгуурт ачигч - SDLG LG953 Бульдозер - Shantui SD16
12	Уурхайн ёроолын түвшин	1610 м
13	Ажлын доголын өндөр	10 м
14	Доголын налуугийн өнцөг	60 градус
15	Ажлын талбайн өргөн	30 м
16	Замын налуу	80-100 промилл
17	Баяжуулах үйлдвэр	Эхний жилд ойролцоогоор 2%-ийн литийн ислийн агуулгатай 150'000 тонн хүдрийг ялган шууд экспортлох, Борлуулалтын орлогоор бага агуулгатай хүдэр баяжуулах үндсэн үйлдвэрийн хөрөнгө оруулалтыг тодорхой хэмжээнд шийдэх шийдэлтэй. Үндсэн баяжуулах үйлдвэр нь: 3 шатны бутлагаа, 1 шатны бөмбөлөгт тээрмийн нунтаглалтай, ангилах болон шламгүйжүүлэх гэсэн 3 шатны гидроциклонтой. Үндсэн хяналтын цэвэрлэгээний флотацийн гэсэн 3 шат дамжлагатай. Хаягдлыг пресс фильтрээр шүүж хаях бол Баяжмалыг туузан фильтр шүүн хатаах цехтэй байх технологийн шийдэлтэй. Үйлдвэрийн хүчин чадал: 300'000 тн/жил

		Хүдрийн агуулга: 0.74% Li ₂ O Металл авалт: 75% Баяжмалын агуулга: 3.5% Чийг: 1.5%
18	Гадаад тээвэр	Эхний жилд: Уурхай – Чойр 250 км автотээвэр Чойр – Эрээн галт тэрэг /чинглэг/ Дараагийн жилүүд: Уурхай –Бага Хангай 41 км автотээвэр Бага Хангай – Эрээн галт тэрэг /чинглэг/
19	Борлуулалтын үнэ	2%-ийн литийн ислийн агуулгатай хүдэр – 87 ам.доллар 3.5% литийн ислийн агуулгатай баяжмал - 315 ам.доллар
20	Нэгж бүтээгдэхүүний өөрийн өртөг	2%-ийн литийн ислийн агуулгатай хүдэр - 87 ам.доллар 3.5% литийн ислийн агуулгатай баяжмал - 315 ам.доллар
21	Хөрөнгө оруулалтын дүн	50,181.8 сая.төг
22	Хөрөнгө оруулалтын NPV	8,172.5 сая төгрөг
23	Хөрөнгө оруулалтын IRR	16.9%
24	Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа	4 жил

Хүснэгт 2. Техник - Эдийн засгийн үндсэн үзүүлэлт

1.3 Ил уурхайн уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө

“Уртын цагаан чулуут” нэртэй литийн хүдрийн ордыг ил уурхайн аргаар ашиглах уулын ажлын календарчилсан төлөвлөгөөг төсөл захиалагчийн техникийн даалгаварт тусгасан хүчин чадалд үндэслэн боловсруулсан болно.

Эхний жилд 280 мян.тн хүдэр (үүнээс 150 мян.тн нь шууд экспорт хийх өндөр агуулгатай хүдэр), ашиглалтын 2 дахь жилээс жилийн 350 мян.тн хүдэр олборлох хүчин чадлаар тооцоход энэхүү ордын ил уурхайн аргаар ашиглах ашиглалтын хугацаа 5 жил байна. Ил уурхайн хүдэр олборлох хүчин чадлыг баяжуулах үйлдвэрийн тооцоололд ашигласан хүчин чадал болох жилийн 300 мян.тн-с илүү авахдаа Захиалагчаас өгсөн баяжуулах үйлдвэрийн нөөц хүчин чадлыг бүрэн ашиглах, бүтээгдэхүүний гарцийг нэмэгдүүлэх боломжтой байх, үйлдвэрийг хүдрийн нөөцөөр бүрэн хангах, шаардлагатай тохиолдолд хүйтний улиралд ил уурхайн үйл ажиллагаа түр зогсоох боломжтой байх.

Уулын ажлын календарчилсан төлөвлөгөөнд ашиглалтын жил бүрд хийгдэх уулын ажлын хэмжээ, хөрс хуулалт, хүдэр олборлолтын хэмжээг дэлгэрэнгүй тооцоолон тусгаж өглөө. Төлөвлөгөөгөөр нөөц бодсон хүдрийн 95%, тогтоогдсон баялгийн 90.5% нь олборлолтод өртөхөөр байна.

Ашиглалт ын жил	Хөрс хуулалт	Сийрэгжсэн хөрс	Хүдрийн нөөц				Эрдсийн нөөц (Li ₂ O)		Хөрс хуулалтын итгэлцүүр	
			Өндөр агуулгатай		Бага агуулгатай		Өндөр агуулгатай	Бага агуулгатай		
	мян.м ³	мян.м ³	мян.м ³	мян.тн	мян.м ³	мян.тн	мян.тн	мян.тн	м ³ /м ³	м ³ /тн
1-р жил	778.86	934.63	53.96	150.00	46.80	130.10	3.04	1.10	7.73	2.78
2-р жил	1250.34	1500.41	-	-	125.90	350.00	-	2.87	9.93	3.57
3-р жил	1560.20	1872.24	-	-	125.90	350.00	-	2.51	12.39	4.46
4-р жил	1200.50	1440.60	-	-	125.90	350.00	-	2.31	9.54	3.43
5-р жил	744.23	893.07	-	-	118.26	328.77	-	2.22	6.29	2.26
Нийт	5534.13	6640.95	53.96	150.00	542.76	1508.87	3.04	11.01	9.27	3.34

Хүснэгт 3. Ил уурхайн олборлолтын ажлын календарчилсан төлөвлөгөө


№	Ашиглалтын жил	Олборлолтонд өртөх талбай	Олборлолтонд өртөх талбай	Овоолгод дарагдах талбай	Овоолгод дарагдах талбай	Шимт хөрсний хэмжээ	Сийрэгжсэн шимт хөрс
		мян.м ²	га	мян.м ²	га	мян.м ³	мян.м ³
1	1-р жил	72.36	7.24	97.63	9.76	51.00	61.20
2	2-р жил	32.44	3.24	35.55	3.55	30.13	36.15
3	3-р жил	15.87	1.59	54.82	5.48	25.97	31.16
4	4-р жил	23.29	2.33	55.82	5.58	30.72	36.87
5	5-р жил	-	-	-	-	-	-
-	Нийт	143.96	14.40	243.82	24.38	137.81	165.38

Хүснэгт 4. Олборлолтонд өртөх талбай, шимт хөрс хуулалтын ажлын календарчилсан төлөвлөгөө

1.4 Баяжуулах үйлдвэр

“Уртын цагаан чулуут” нэрт ордын Литийн хүдрийг баяжуулах хамгийн тохиромжтой технологийн шийдэл нь буталж нунтаглан хөвүүлэн баяжуулах технологи байна.


Баяжигдах шинж чанарыг тогтоох туршилтын үр дүн, технологи, тоног төхөөрөмж нийлүүлэгч компаниудын саналд үндэслэн “Уртын цагаан чулуут” ордын хүдэр баяжуулах үйлдвэрийн Технологийн схемийг дараах байдлаар загварчласан байна.



Зураг 3. “Уртын цагаан чулуут орд”-н Литийн хүдэр баяжуулах үйлдвэрийн технологийн ерөнхий схем

Хүдэр баяжуулах үлдвэр нь 3 шатны бутлалт, 1 нэг шатны нунтаглалттай, нунтаглагдсан хүдрийг гидроциклоноор ангилах, хэт нунтаглагдсан хүдэр буюу шламыг ялгах 2 шатны гидроциклон бүхий ангилах хэсэгтэй, Үндсэн болон хяналтын 3 цувраа хөвүүлэн баяжуулах танк, Үндсэн баяжуулалтаас гарсан баяжмалыг 3 шатны цэвэрлэгээний хөвүүлэн баяжуулах шугамаар цэвэрлэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, баяжмалыг Өтгөрүүлэгчээр дамжуулан пресс фильтрээр шүүн савлах (шаардлагатай бол хатаах), Хаягдлыг мөн адил өтгөрүүлэгчээр дамжуулан пресс фильтрээр шүүн хаягдлын даланд хадгалах шийдэлтэй байна. Анхдагч гидроциклоны халианы шугамд шигшүүр болон соронзон сеператор суурилуулна. Ингэснээр баяжмалд оргоник бохирдол, тэсэлгээний утас зэрэг бусад ханган бохирдлыг бүрэн ялгах боломж бүрдэнэ.

Дээрх үндсэн шийдлээс гадна Баяжуулах үйлдвэрт тоос цуглуулах, химийн бодис найруулах тугнах, өндөр болон нам даралтын хий хангамж, Түүхий болон технологийн ус хангамж, баяжмал хатаах салах хэсэг, Баяжмалын агуулах - ачих хэсэг, Засвар үйлчилгээний хэсэг, Чанарын хяналтын лаборатори + технологийн судалгааны хэсэг зэрэг нэгжүүдтэй байна.



Зураг 4 .Баяжуулах үйлдвэрийн талбайн төлөвлөлт

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ НУТАГ ДЭВСГЭРИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

Газарзүй

Төв аймгийн Эрдэнэ сум нь тал хээрийн бүсэд хамаарагддаг. /Засгийн газрын 2006 оны 71-р тогтоол/ Эрдэнэ сум нь Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хэнтийн мужид Хэнтийн захын хэсгийн тойрогт багтана. Геоморфологийн хувьд Хэнтийн уулын тогтолцооны салбар уулын өмнөд хэсэг болох жижиг толгодорхог гадаргуутай бүсэд багтдаг. Орчин үеийн рельефийн бүрдэлтэд дотоод болон гадаад хүчин зүйлийн процесс ихээхэн үүрэг гүйцэтгэж, орчин үеийн рүльефийн дүр төрхийг бүрдүүлсэн. Идэгдэл-элэгдэл маягийн рельефт голын зарим нэг хажууг оруулах ба энэ нь идэгдлийн гадаргатай шинжээ алдсан байх нь ажиглагддаг. Хөндийн I ба II дэнж бүрэлдсэн дээд плейстоцены настай, өндөр нам татмууд бөгөөд эдгээрийн өргөн нь 50-1000 м. Гольдрол нь гол төлөв 0.2-1.0 м гүн, 0.510 м өргөнтэй байна. Угаагдлын үр дүнд үүссэн хуримтлалын гадаргуу нь хажуугийн буюу делювийн бөөгнөрлөөс тогтоно.

Цаг агаар

Монгол орны уур амьсгалын мужлалтаар Төв аймгийн нутаг дэвсгэр уур амьсгалын хувьд чийглэг хүйтэн, чийглэгдүү хүйтэвтэр, хуурайдуу хүйтэвтэр, хуурай дулаан гэсэн 4 мужид хуваагддаг бөгөөд төсөл хэрэгжиж буй газар нь хуурайдуу хүйтэвтэр мужид хамаарна. Энэ муж нь чийгийн хэмжээ дунд зэрэг, дулааны хүрэлцээ сайн, түрүүчийн мужийн адил эрт хүйтэрч орой дулаарах ба чийгшлийн хувьд бусад мужуудаас арай илүү.

Нутаг дэвсгэр уур амьсгалын мужлалаар дулаавтар зунтай хагас чийглэг мужид хамаарна. Сумын нутаг дэвсгэр нь Хэнтий нурууны 2000-2700 м хүртэл өргөгдсөн, гол салбар уулсыг хамарч байгаа бөгөөд ерөнхийдөө чийг тунадас харьцангуй их, чийг дулааны коэффициент 2.2-оос дээш боловч дулаан дутагдалтай учир ургамалын өсөлт, хөгжилтэнд таатай биш, ургамал ургалтын хугацаа 90 хоногоос цөөн байдаг. Агаарын темпартур нь 79-84 хэм байна. Хоногийн хэлбэлзэл нь 20-25 хэмд хүрдэг ба энэ нь их газрын эрс тэс уур амьсгалын үндсэн шинж юм. Зун богино бөгөөд халуун биш хамгийн халуун нь 7-н сард дунджаар +15.6-37 хэм. Ойн хөвчдөө үүнээс ч бага, өвөл хүйтэн бөгөөд урт дундаж, темпартур нь -21-27 хэм, үнэмлэхүй хамгийн бага темпартур нь -41-46 хэм байна.

Гадаргын болон гүний ус

Монгол орны усны сав газрын хувьд Эрдэнэ сумын нутаг дэвсгэр нь Хэрлэн голын сав газарт хамаарагдаж байна.

Гэвч тухайн бүс нутагт буюу төслийн байршил орчимд ямар нэгэн гадаргын усны сүлжээ илрээгүй ба тухайн төслийн байршлын орчимд түр зуурын буюу хүчтэй аадар бороо орсны дараагаар түр зуурын ус тогтох магадлалтай байсан судалгааны явцад харагдаж байсан.

Зэргэлдээх талбайнуудад хийгдсэн судалгаанаас үзэхэд энэ насны хурдасны доод хэсэгт элсэрхэг шаварлаг хурдас тогтоогдсон байна. Энэ шаварлаг хурдасны дээд үе болон дунд нь илрэх хэмхдэслэг үеүүд ус агуулдаг онцлогтой байна. Усны

төвшин дунджаар 6.0-7.0м-ийн гүнд, хөндийн адагт 9.0м хүрдэг байна. Уст үеийн зузаан 5.0м хүрэх тул үйлдвэрлэлийн зориулалттай усны хэрэгцээг хангахад энэ насны уст давхарга голлох үүрэгтэй.

Агаар орчин

Хавар, зуны улиралд цаг агаар, хөрсний хуурайшилт, салхи шуурга ихтэй үед хөрс, автозамын сул шороо болон барилга, зам засвар зэрэг бүтээн байгуулалтын үйл ажиллагаанаас шалтгаалан газрын гадаргаас агаарт дэгдэх тоосонцор ихэсдэг ба ялангуяа автозамаас үүссэн тоосонцор нь агаарыг ихээр бохирдуулдаг байна (Дэлхийн банк, 2011). Тэгвэл өвөл, намрын улиралд түүхий нүүрс, модны шаталтаас гарах утаа, дизель хөдөлгүүрт автомашины хаягдал утаа, мод ургамлын хатах, унах процесс зэрэг улирлын онцгой нөлөөллүүд болон цаг агаарын төлөв байдал /температур, салхины хурд, инверс, тунадас/ зэргээс шалтгаалан агаар дахь том болон нарийн ширхэглэгт тоосонцорын хэмжээ нэмэгддэг байна.

Хөрсөн бүрхэвч

Төсөл хэрэгжихээр төлөвлөгдсөн Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг нь газрын гадаргуугийн хувьд ухаа жалга, тал бүхий уул толгод, өндөрлөг сэрвэн хад чулуу элбэгтэй уулархаг гадаргуу болон түүний хоорондох хотгор газраас бүрдэх бөгөөд өндөр нь 1500-1700 м орчимд хэлбэлзэнэ. Энэ газар нь хөрс-газарзүйн мужлалтаар хар хүрэн хөрстэй Халхын дундад талын тойрогт багтана. Ургамал бүрхэвчид агь-хазаар өвс-хялганат, хялгана-хазаар өвст хээр эрс давамгайлахын сацуу үетэн-агь-харганат хээр, мөн өндөрлөг уул толгодын бэлээр бушилзат хээр зонхилно. Судалгааны талбайн хэмжээнд тархсан хөрсөн бүрхэвчид уулын ердийн харшороон болон ердийн хархүрэн хөрс зонхилох суурийг эзэлнэ.

Судалгааны талбайн уулт атриат өргөгдлийн элэгдэл-тектоникийн гаралтай гадаргатай байна. Газрын гадарга дээр хотгор гүдгэрийг өөрчлөгч орчин үеийн үйл явцын эрчим сул, усны нэл угаагдал зонхилно. Антропогений нөлөөнд харьцангуй бага өртсөн, харин ердийн хөрсөн замын улмаас хөрсний дээд өнгөн үе давхарга элэгдэл, эвдрэлд өртсөн байдалтай байна. Мөн тухайн төслийн байршил нь 2 овооны голоор байрлах ба тухайн 2 овооны голоор жалга ихтэй ба хөрсний эвдрэлд нэлээдгүй их орсон байдалтай байх ба 0.7 га газар жалгатай хөрс жалгаар урсах борооны уснаас болж хүчтэй эвдэрсэн байдалтай байна. Тухайн судалгааны явцад хөрсний 2 дээж авч Газарзүй, Гео-Экологийн хүрээлэнгийн хөрс судлалын газраар шинжилгээ хийлгэсэн ба тухайн хөрсний судалгааны 2 дээжийг шинжилгээнд өгсөн.

Төслийн талбайн агрохимийн дүн шинжилгээнээс авч үзэхэд тухайн төслийн талбайн хөрсөн бүрхэвчтэй гадаргын агрохимийн үзүүлэлтүүд нь тухайн хөрс нь рН-ийн агууламж урвалын орчин саармагжсан байх бөгөөл давсны агууламж бага ялзмагын агууламж нь 5,22%-6.46% буюу ялзмагын агууламжаар баялаг, шим тэжээлийн элементийн агууламж сайтай байна.

Ургамал бүрхэвч

Тус бүс нутагт буюу Төв аймгийн Эрдэнэ сумын нутгийн баруун хэсэг нь хээрийн бүсэд хамаарагдах ба тухайн бүс нутгийн ургамлын хэв шинж нь говь-

хээрийн бүсэд түлхүү ургадаг ургамал зонхилох хандлагатай байгаа нь судалгааны явцад ажиглагдсан.

Энэ газар нутаг нь ургамал газарзүйн мужлалын хувьд Евразийн хээрийн мужид хамаарна. Энэ тойрогт шивээт хялгана-хазаарганат (*Stipabaicalensis-Cliestogenessquirossa*), шивээт хялганат-агьт (*Stipabaicalensis-Artimisiafrigida*), шивээтхялганат-өлөнт (*Stipabaicalensis-Carixdiriuscula*), харганат - (*Caragana*), харгана-агьт (*Caragana-Artemisiafrigida*) үетэнт зонхилох ба нийт 509 дээд ургамал байдгаас 403 өвслөг, 63 зүйл нь модлог, сөөглөг юм. Судалгааны объектын орчим жижиг бутлаг үетэн-хялганат бүлгэмдэлд *Stipa krylovii*, *Cliestogenes squarrossa*, *Koelera cristata*, *Sibbaldianthe adpressa*, *Haplophyllum dauricum*, *Astragalus galactites* зонхилж байсан болно.

Энэ бүс нутаг нь талын ландшафтын өндөрлөг талын (1115-1128 м хүртэл) бага хэрчигдэлтэй, элэгдлийн умард хуурай хэсгийн ландшафттай. Байгалийн мужлалын хувьд давхаргат өндөрлөг тал, үлдмэл цулдмал уул бүхий хуурай хээрийн дэд мужийн 10 %-аас бага мараа-марз бүхий Умард хуурай хээрийн районд хамаарна.

Амьтны аймаг

Монгол орны төв хэсгийн хээрийн ургамалшилтай нутагт олон салаа гүн нүх малтан орогнож голдуу ногоон өвсөөр хооллогч мэрэгчид зонхилно.

Хуурай хээрийн бүсэнд мэрэгчид дундаас үлийн цагаан оготно хамгийн дэлгэр тархана. Ялангуяа Монголын Дорнод талд өргөн тархаж Хангайд зөвхөн гол нурууны өвөр хажуугаар оршин Хан хөхийн нуруунаас баруун тийш үл үзэгдэнэ. Үлийн цагаан хулганы удаах байранд дагуурын үхэр огодой орох боловч түүнтэй адил тийм асар их тоонд хүрэхгүй. Хээрийн бүсийн зүүн ба зүүн хойт этгээд дэх арай чийглэг хиаг-хялганат хээрт дагуурын зурам элбэн дайралдана. Хээрийн бүсийн элсэрхэг газраар шар сүүлт, чичүүл тархдан бөгөөд заримдаа сүрхий шигүү оршино. Чичүүл нь говийн бүсэнд илүү нийтлэг тул хээрийн бүсэнд зөвхөн элстэй нутгаар л дайралдана. Бусад мэрэгчдээс Сибирийн алаг даага, хөх ишнүүхэй, орог зусаг, тарвага, туулай гэх мэрэгчдийг нэрлэж болох бөгөөд сибирийн алаг даага нь өндөр уул, цөлийн бүс 2-оос бусад газарт өргөн тархдаг бөгөөд Монголын дорнод талд нарсан өвст, агь-хялганат, хялганат хээрт, Хангай, Монгол Алтайн уулст ботуульт-хээрт голчлон дайралдана.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт хэрэгжүүлж буй “Уртын цагаан чулуут литийн ордыг ил аргаар ашиглах” төслийн хувьд байгаль орчны төлөв байдал, байгаль орчны эрх зүйн байдал зэрэг нь байгаль орчныг хамгаалах асуудалтай хэрхэн уялдах, төслийн үйл ажиллагаанаас хамрах нутаг дэвсгэрийн орчны бүрдэл хэсгүүдэд төслийн хэрэгжих үе шат бүрийн үйл ажиллагааны нөлөөлөл, түүнчлэн төслийн гол нөлөөллийг үнэлэн тогтоов.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан, БОНХЯ-наас гаргасан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний аргачилсан заавар /2014/, байгаль орчны нөлөөллийн

үнэлгээнд өргөн хэрэглэгддэг матриц, магадлан жагсаах, давхцуулан зураглах, загварчлалын арга, харьцуулсан судалгааны арга, зэргийг ашиглан хийж гүйцэтгэлээ.

Үүнд:

Шууд нөлөөлөл:

- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизм, тоног төхөөрөмж болон хүний анхаарал болгоомжгүй байдлаас шатахуун, тослох материал шүүрч, асгарах байдлаар хөрсийг бохирдуулах;
- Уурхайд хөрсний овоолго хийх, хүдэр хөрс чулуу тээвэрлэх зэрэг үндсэн үйл ажиллагаанд хүнд даацын олон машин ажиллахад хөрс их хэмжээгээр элэгдэл, эвдрэлд орж, хөрсний үржил шим алдагдах;
- Хүдэр олборлох, тээвэрлэх явцад машин механизмуудын түлшний шаталтаас гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий гэх мэт/;
- Ил уурхайн аргаар ашигт малтмал, эрдэс түүхий эдийг олборлоход агаарт их хэмжээний тоос ялгарах;
- Бульдозер, ачигч зэрэг машин механизмуудаар хөрсийг хуулах овоолго хийх үеийн тоосжилт;
- Аадар борооны үед талбайд түр зуурын үерийн ус бууж талбай дахь хөрс, шавар, хатуу шингэн хог хаягдал, хагшаас зэргийг урсгаж орчныг бохирдуулж болзошгүй;
- Төслийн үйл ажиллагаанаас ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал хөрсийг бохирдуулснаас гүний усанд шууд бусаар нөлөөлж болзошгүй;
- Ил задгай хатуу шингэн хог хаях нь хөрс, ургамал бохирдуулах;
- Газар шорооны ажлын үед ургамлын шимт үе хөрсийг хуулах;
- Хөрс хуулах, хөрсний овоолго хийх үед дарагдах;
- Төслийн явцад бусад зориулалтаар газар ашиглахад ургамлын төрөл зүйл устаж үгүй болох, хувьсаж өөрчлөгдөх;

Шууд бус нөлөөлөл:

- Гадаргын усны чанарт барилгын ажлын хаягдал, орчны дуу чимээнд техникийн дуу чимээ зэрэг сөрөг нөлөөлнө.

Хүчтэй нөлөөлөл:

- Литийн олборлолтын үед газрын хэвлий хүчтэй нөлөөлөлд өртөнө.

Төсөлд ашиглагдаж байгаа Эрдэнэ сумын нутаг дэвсгэр орчимд учирч болзошгүй сөрөг нөлөөллүүдийг байгалийн хам бүрдлүүдтэй уялдуулан тодорхойлж хүснэгт 5.-д үзүүлэв.

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж чанар, өртөгдлийн байдал
---	----------	---	--

<u>Нэг. Агаар орчин</u>			
1.	Тоосжилт	- Тээвэрлэлт (бүтээгдэхүүн, барилгын ажлын болон ахуйн хэрэгцээний бүх төрлийн хангамж, түлш, хог хаягдал)	- Улирлын чанартай, тархах хүрээ хомс, хатуу хучилттай замаар төслийн талбай хүрдэг.
1.2	Дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хий, утаа, угаар	- Автомашин	- Агаарыг бохирдуулах боловч хадгалагдах болон тархах хүрээ хязгаарлагдмал
<u>Хоёр. Усан орчин</u>			
2.1	Хатуу болон шингэн хог хаягдал	- Ахуйн болон шатах тослох материалын хаягдал - Бохир ус дамжуулах хоолойн бүрэн бус байдал - Хүмүүсийн анхаарал хайхрамжгүйн улмаас асгарах, гоожих	- Хөрс болон хөрсний ус бохирдох магадлалтай. - Хур борооны усаар угаагдаж хөрсний ус бохирдуулна.
<u>Гурав. Хөрс</u>			
3.1	Элэгдэл, эвдрэл,	- Явган жим, зам гарах, дагтарших, талхлагдах -Тээвэрлэлтийн зам үүссэнээр хөрсөн бүрхэвч элэгдэх - Төслийн ашиглалтын үе шатанд хөрсөн бүрхэвч эвдэрх	-Хэмжээ хязгаарлагдмал -Хөрсний физик, механик шинж чанар өөрчлөгдөж болно -Хөрс эвдэрч элэгдэж болно. - Ямар нэг хэмжээгээр нөхөн сэргээх боломжтой.
3.2	Бохирдол	- Ахуйн хог хаягдал	-Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн шинж чанар өөрчлөгдөнө.
<u>Дөрөв. Ургамал бүрхэвч</u>			
4.1	Ургамлын талхлагдал	-Автомашин болон явган хүний зам, мөр	-Хэмжээ хязгаарлагдмал
4.2	Ургамлан нөмрөг устгах	- Нэн ховор, ховор ургамлыг таньж мэдэхгүй устгах	- Төрөл, зүйл өөрчлөгдөж болно. -Төрөл, зүйл устаж болно. -Хэмжээ хязгаарлагдмал
4.3	Хордолт	- Ахуйн хог болон шатах тослох материалын хаягдалаар хордох, -Төсөлд ашиглагдах химийн бодисуудаар хордох	-Ургамлын биомассын хэмжээ багасна - Ургамлан бүрхэвч эргэлт буцалтгүй устаж болно - Ургамлын генд өөрчлөлт орж болно
4.4	Талхлагдах	- Хүний хөл хөдөлгөөн, үйл ажиллагаанд байнга өртөж буй зөрөг зам, жим, - Ашиглалтын талбай, барилга объектуудын орчин	- Ургамлын төрөл зүйл устаж болно - Ургамлыг нөхөн сэргээхэд бэрхшээлтэй болж болно.
<u>Тав. Ан амьтан</u>			

5.1	Хордолт	- Шатах тослох материалын болон ахуйн хаягдал -Химийн сав баглаа боодлын хаяглаар бохирдох	-Хөрсөн дэх бичил биетэн, шавьж хорхой үрэгдэж болно. -Амьтдын удамшил генд өөрчлөлт орох магадлалтай
<u>Зургаа. Нийгэм эдийн засгийн орчин</u>			
6.1	Үйлчилгээний төв, зочил буудал, газрын теннисний талбай	- Эдийн засгийн чадавхи дээшилнэ	-Хүний танин мэдэхүйд дэвшилттэй, соёлыг түгээх зэрэг эерэг нөлөө их
6.2	Үндсэн хөрөнгө	- Татварын эх үүсвэр	- Улсын төсөвт хувь нэмэр оруулах
6.3	Шинээр ажиллагсад авна	- Ажлын байр шинээр бий болно	- Орон нутгийн иргэдийн ахуй амьдралд тус дөхөм үзүүлнэ. - Тогтмол бус

Хүснэгт 5. Болзошгүй нөлөөлөл байгалийн хам бүрдэлтэй уялдах нь

Дээрх ажлын хүрээнээс үүсэх нөлөөллүүдийг бууруулах, сэргийлэх зорилгоор дараах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

“Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-д аж ахуйн нэгж бүр төслийн үйл ажиллагааны үед гарч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг жил бүрийн төсөл (үйлдвэр-санхүүгийн) төлөвлөгөөндөө тусгаж ажиллах нь зүйтэй гэсэн зүйл заалттай. Иймээс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлж байхыг зөвлөж байна.

Гол нөлөөллийн үнэлгээг үндэслэн тус түүхий эд буулгаж, ачих байгууламж, төслийн барилга байгууламж барьж байгуулах, үйлдвэрийн цаашдын үйл ажиллагааны явцад гарч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээх замаар тухайн орон нутгийн байгалийн өнгө төрх, хэлбэр, хор аюулгүй нөхцөлд орон нутгийн хүн ам, амьтан ургамал, үржин төлжих нөхцөлийг бүрдүүлэхэд үйл ажиллагааны гол зорилго оршино. Иймд төслийн болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

4.1 Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилго, зорилт

Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаврыг хянах үүрэгтэй.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт байрлах “Уртын цагаан чулуут литийн ордыг ил аргаар ашиглах” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн бөгөөд төсөл хэрэгжүүлэгч төслийн хэрэгжүүлэх нийт хугацаанд энэхүү үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй.

БОМТ-ын үндсэн зорилгыг хангахын тулд төсөл хэрэгжүүлэгчийн санхүүгийн чадавхын хүрээнд нийгмийн хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн дараах зорилтыг хангана.



Үүнд:

1. БОМТ-нд тусгасан ажлын дараалал, түүнийг хийж гүйцэтгэснээр хүрэх үр дүнг нөхөн сэргээлтэд тавих шаардлагын хэмжээнд хүргэх;
2. БОМТ-ний хэрэгжилтийг төсөл хэрэгжүүлэгч өөрөө болон орон нутгийн оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх;
3. БОМТ-г зохих ёсоор хэрэгжүүлснээр төсөл хэрэгжүүлэгчийг хөндлөнгийн хяналт, шалгалтад бэлэн байлгах зэрэг нөхцөлүүдийг тодорхойлно;

Уг төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй нөлөөллүүд дээр үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, зэрэг ажлууд багтсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь:

1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
2. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Иймд 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт **99,200,000** төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах аргазүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж өгсөн.

№	Ажлын нэр	Зардал /мян.төг/
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал	72,400
2	Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн зардал	26,800
2025 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөний нийт зардал		99,200

Хүснэгт 6. БОМТөлөвлөгөөний зардлын задаргаа /мян.төг/

4.2 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн харуулж буй төсөл хэрэгжүүлэгчийн заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд ба түүнтэй холбогдох бусад зураг төслийн буюу туслах ажлуудын зардал ороогүй.

Энэхүү төлөвлөгөөнд тусгасан байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүд нь зөвхөн “Литиум сенчури” ХХК-ийн хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаанд зориулагдсан болно. Төслийн хүчин чадал өөрчлөгдөх, нэмэгдэх бүрд

төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийлгэж байх шаардлагатай. Мөн энэхүү БОХТ-ний ихэнх хэсэг Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй нягт уялдах тул төслийн хэрэгжилтийн бүхий л хугацааны туршид газрын доорх ус, хөрсний чанар, ургамалжилт, амьтны аймагт гарч байгаа өөрчлөлтүүдийг тухай бүрд нь шинжилж, холбогдох арга хэмжээг жил бүрийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байх шаардлагатай.

Төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллах хэрэгтэй.

- БОХТ-ний хэрэгжилтийн талаарх тухайн жилийн хяналт, судалгаа шинжилгээгээр төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр, түүний ойр орчмын нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд дүгнэлт хийх ажлыг байгаль орчны хяналт шинжилгээний ажлын үр дүнгүүдэд үндэслэн хийх;
- БОХТ-ний биелэлтийг дүгнэхдээ тухайн жилийн хяналт, судалгаа шинжилгээгээр төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудын холбогдох хяналтын байцаагч нар, ард иргэдээс тавих шаардлага, хүсэлтийг хэрхэн хангасныг мөн авч үзэх;
- БОХТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 11 дүгээр сарын 15-ны дотор Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам, Эрдэнэ сумын Тамган багын оршин суугчдад танилцуулж, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;

№	Хийгдэх ажил	Зардал /мян.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээ	2,400
2	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	40,700
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	12,500
4	Орчны тохжилт цэцэрлэгжүүлэлт, нөхөн сэргээлтийн зардал	13,000
5	БОМТ-ний хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	3,800
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	26,800
7	Нийт зардал	99,200

Хүснэгт 7. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал /мян.төг/

4.2.1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгана. Байгаль орчны үндсэн бүрдэл хэсгүүд (агаар, ус, хөрс, газрын гадарга, амьтан гэх мэт)–ээр төслийн үйл ажиллагааны хугацаанд биелүүлэх ерөнхий төлөвлөгөөг тооцож гаргасан удирдах дээд байгууллагаар баталгаажуулан, хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн төлөвлөгөөнд байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, сэргийлэх арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан болно.

Төсөл хэрэгжүүлэгч нь хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахдаа төслийн болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар дараах арга хэмжээг авч, хэрэгжүүлэх шаардлагатай.

Гол болон болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ хүрээ	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
АГААРЫН ЧАНАР						
Төслийг Хэрэгжүүлснээр агаар бохирдох, тээврийн хэрэгслийн утаа, хог хаягдал зэрэг сөрөг нөлөөлөл үүсэж болзошгүй	Агаарт тоос их хэмжээгээр дэгдсэн үед болон баяжмал буулгах ачих үед хөдөлмөр хамгааллийн хувцас хэрэглэлээ хэрэглэх талаар анхааруулах самбар байрлуулах, сургалт явуулах	Төслийн талбайд	2000.0		Жил бүр	- Агаарын тухай хууль, - MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - Халаалтын ба гэрийн зуухны яндангаар гарах утааны найрлага дахь агаар бохирдуулагч бодисын хүлцэх дээд хэмжээ ба хэмжих - Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага:
	Агаарын бохирдол хэмжих төхөөрөмж аппаратыг төслийн талбайд суурилуулан, хяналт тавьж ажиллах	Уурхайн талбай дотор байрлуулах	Үйл ажиллагааны зардал		2025 онд	
	Тээврийн хэрэгсэлд оношилгоо, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Машин техник	Дотоод зардлаар		Жилд 2 удаа	
	Үүсэх ахуйн хог хаягдлыг зохих ангиллын дагуу ангилж зохих хаягдлын цэгт хаях, шатаахгүй байх	Хог хаягдлын цэг орчимд	Хог хаягдлын менежментэд тусгагдсан			
	Агаарын мониторинг хийх	Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан			Жилд 4 удаа	

ГАДАРГЫН УС БОЛОН ГАЗРЫН ДООРХИ УСАН ОРЧИН					
	Ахуйн хэрэглээнээс гарах бохир усыг цэвэршүүлэн ногоон байгууламжийн усалгаанд ашиглах	Ариун цэврийн байгууламж	Дотоод зардалаар	2025 он	- MNS 13.060.50 Усны чанарын стандарт - Усны тухай хууль
	Ус ашигласны төлбөрийн цаг тухайд төлж барагдуулж байх	Үйл ажиллагааны зардал		Өдөр бүр	- MNS 4943:2015 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага
	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг хэмнэлттэй байдлаар ашиглах шаардлагын хүрээнд ариун цэврийн өрөө, шүршүүр мэдрэгчтэй төхөөрөмж суурилуулж усыг хэмнэх	Ариун цэврийн өрөөнд	400.0	2025 онд	
ХӨРСӨН БҮРХЭВЧ, ГАЗРЫН ГАДАРГА, УРГАМЛЫН НӨМРӨГ					
Төслийн үйл ажиллагааны улмаас газрын гадарга, хөрс эвдрэх, ургамлан бүрхэвч устах хөрс хог хаягдлаар бохирдох	Хог хаягдлын түр хадгалах цуглуулах цэг байгуулах	Төслийн талбайд	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	2025 он	- MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, - MNS5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ - Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
НИЙТ ЗАРДАЛ /МЯН.ТӨГ/				2,400 мян.төг	

Хүснэгт 8. Болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээ

4.2.2 Орчны тохжилт цэцэрлэгжүүлэлт, нөхөн сэргээлтийн зардал

Төслийн үйл ажиллагааны улмаас газрын гадаргын төрх байдал өөрчлөгдөж доройтох төдийгүй газрын хэвлийд нөлөөлөл үүснэ. Сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах үүднээс үйл ажиллагааны туршид дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

Газрын тухай хуулийн 56.6. тоотод зааснаар Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана. Тус төслийн талбайн нийт 4.807 га талбай байна. Үүнээс нийт талбайн 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх ногоон байгууламжтай болгох шаардлагатай.

“Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай” хуулийн 7дугаар зүйлийн 7.2-д заасан Хот тосгон, суурин газрын хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэхэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- 7.2.1.иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон цэгээс бусад газарт хөрсийг хог хаягдлаар бохирдуулахгүй байх;
- 7.2.2.иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эрүүл ахуйн шаардлага хангасан бохир ус зайлуулах байгууламжтай байх;
- 7.2.3.барилга байгууламж барьж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь барилгын ажлын явцад болон дууссаны дараа эвдэрсэн газрын хөрсийг нөхөн сэргээх;
- 7.2.4.иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн болон өмчлөлийн газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх; /өөрийн эзэмшлийн талбайд тохижуулах боломжгүй бол нийтийн эзэмшлийн талбайд агаар орчны бохирдлоос сэргийлэх арга хэмжээг заавал авч хэрэгжүүлэх/

Төсөл хэрэгжүүлэгч нь тарьсан олон наст өвслөг ургамал бүхий ногоон байгууламжийн ургалтад анхаарал, хяналт тавих, усалгаа, тордлогоор байнга хийх, хүнд машин механизм болон хүний үйл ажиллагаагаар хугарч гэмтэх, халцарч, зулгарахаас хамгаалах арга хэмжээг цаашид авч ажиллах нь зүйтэй.

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн зардал /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг

Газрын эвдэрсэн хэсгийг цэвэрлэх хөрс сайжруулах, ургамалжуулах нөхөн сэргээлт хийх	Талбайд мод бут тарьж зүлэгжүүлэх, орчны тохижилт	Төслийн ил задгай үлдсэн талбайд болон нийтийн эзэмшлийн талбайд /66 га/	10,000.0	2025 он	- Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918 : 2023 -Мод, сөөгний суулгац арчлах MNS6258-2:2011 - Ургамал хамгаалах тухай хууль - Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
Ногоон байгууламжийн ургалт сайжруулах, хүнд машин механизм болон хүний үйл ажиллагаагаар хугарч гэмтэх, халцарч, зулгарахаас хамгаалах	Ургалтад анхаарал, хяналт тавих, услах арга хэмжээг авах, ногоон байгууламжийн орчимд хаалт, хамгаалалт тавих/	Нийт ногоон байгууламжийн орчимд	3000.0	2025 он	
НИЙТ ЗАРДАЛ /МЯН.ТӨГ/			13,000.0 мян.төг		

Хүснэгт 9. Нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, зардал

Нэг ширхэг улиас ургалтын хугацаандаа 28 кг тоос шороог өөртөө шингээдэг. Тийм учраас 2-оос дээш настай улиас тоосжилтын эх үүсвэрийн орчимд улиас салхины дээд талаар харин шар хуайсыг зам дагуу 30 см гүн, 20 см өргөнтэй шуудуу татан хашлага хэлбэрээр тарина. Хашааны баруун талаар ногоон байгууламжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Зүлэг тарих зөвлөмж

1. Талбайгаа зүлэгжүүлэхийн өмнө шим тэжээл муутай газрын хөрсийг 20-30 сантиметр гүн хагалж хайрга чулууг цэвэрлэж аваад үлдсэн шороог зөөсний дараа хүрэн хөрсийг 2.5х2.5 сантиметрийн гишгүүрээр гишгэж, ургамлын үндэс болон бусад хогноос цэвэрлэж, гишгэсэн хар хүрэн хөрсийг 20 сантиметрээс доошгүй зузаан дэвсэж гадаргууд жигд тарааж тэгшилснээр зүлэг тарих талбай бэлэн болно.
2. Үрийг нэг метр квадрат талбайд 50-80 грамм орохоор тооцоолж салхи багатай тогтуун өдөр талбайд жигд цацаад тармуураар самнасны дараа элсээр нэгээс хоёр сантиметр зузаан хучин.
3. Үүний дараа 50-100 килограмм жинтэй булаар булдаж зөөлөн шүршиж усална.
4. Зүлэгжүүлэх ажлыг тавдугаар сарын хоёрдугаар хагасаас 7 сарын 10-нд багтааж тарьдаг байна.

5. Тарьсан үрээ соёолтол хөрсийг нь чийгтэй байлгахын тулд өдөр бүр өглөө оройн сэрүүнд нэг метр квадрат талбайд 30-40 литр ус, үр соёолсноос хойш нэг метр квадрат талбайд 20-30 литр ус орохоор бодож долоо хоногт гурваас дөрвөн удаа услах бөгөөд гандуу үед өдөр бүр услах хэрэгтэй.

4.2.3 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Тухайн төсөл хэрэгжиж буй газар нь Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг буюу айлын өвөлжөө хаваржаа байхгүй суурьшлын бүсэд хамаарахгүй. Иймд “Уртын цагаан чулуут литийн ордыг ил аргаар ашиглах” төслийн ойр орчимд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөх шаардлагагүй.

4.2.4 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Соёлын өвийг хамгаалах, хадгалах Монгол улсын хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх
- Төслөөс шууд өртөж нөлөөлөгдөхөөргүй цэгүүдийг хамгаалах ажиллагаа, соёлын ба үнэт өв дурсгалтай газрыг хамгаалах төлөвлөгөө,хөтөлбөрийг боловсруулахдаа төв, орон нутгийн удирдах байгууллага,мэргэжилтнүүд,орон нутгийн олон нийтийн байгууллага, ШУА-ын Археологийн Хүрээлэн зэрэгтэй зөвлөлдөнө.Энэ төлөвлөгөө, хөтөлбөрийг төслийн бүтээн байгуулалт эхлэхээс өмнө төлөвлөж мөрдөх.

4.2.5 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө



Төслийн үйл ажиллагааны үед технологийн горимыг чанд сахихгүй байх, ажиллагсдын хайнга ажиллагаа зэргээс үүдэн осол гарвал төсөлд ашиглагдаж буй бүтээгдэхүүний хор аюулаас үүдэн бий болох эрсдэл, үр дагавар нь ноцтой тул урьдчилан сэргийлэх иж бүрэн арга хэмжээ авч, эрсдэлийг бууруулах, аюулгүй байдлыг хангах талаар бэлтгэл ажлыг зохих журмын дагуу хийсэн байх зайлшгүй шаардлагатай.

Болзошгүй аюул, ослын сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
--------------------------------------	---------------------------------	---------------------------	-------------------------	----------------------	--------------------------------	---------------------------------

Болзошгүй осол, саатал, химийн бодис асгарах, техник технологийн дуу чимээ, галын гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Төслийн талбай, барилга байгууламж	2000.0	Улирал бүр	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль -Галын аюулгүй байдлын тухай /шинэчилсэн найруулга/ -MNS 5566:2020 Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм -MNS 6470 :2014 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага
	Шатах тослох материал, шатахуун асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгслийг ажлын талбарт бэлэн байлгах	Төслийн талбайд, ШТС орчимд	5000.0	Тогтмол	
	Ажилчдад хор тайлах бүтээгдэхүүн олгож байх /витаминжуулсан ундаа, сүү/	Бүх ажилчдад	Үйл ажиллагааны зардал	Улирал бүр	
	Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Бүх ажилчдад	500.0	Жилд 1 удаа	
	Гал түймрээс урьдчилан сэргийлэх тусгай бүдүүвч схем боловсруулан батлах, гал унтраах хэрэгслээр бүрэн хангах арга хэмжээ авах	Төслийн хүрээнд	5000.0	Жилд 1 удаа	
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох дүүргийн байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Бүх ажилчдад	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Жилд 1 удаа	
	Ажилчдыг ХХАА-ны багаж, хувцас хэрэгслээр хангаж ажиллах	Бүх ажилчдад	Дотоод зардлаар	Улирал бүрийн хувцас	
	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэг хамруулах	Бүх ажилчдад	Дотоод зардлаар	Жилд 2 удаа	
	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал		12,500.0 мян.төг		

Хүснэгт 10. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны үед хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангах нийтлэг журмын дагуу осол аваарь гарахаас урьдчилан сэргийлэн дараах багаж хэрэгсэл болон тохирох тэмдэг тэмдэглэгээг ашиглана.

Галын сарай		Галын хөрөө	
Галын хайрцаг иж бүрдэл		Галын дэгээ	
Элсний хайрцаг		Галын лоом	
Галын хөнжил		Галын сүх	
Утаа мэдрэгч		Галын царил	
Галын хувин		Галын цохиур	

ГАЛЫН ХОРНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ ТӨРӨЛ

НУНТАГ ГАЛЫН ХОР

-  Мод даавуу, органик нэгдэл
-  Бензин, шатамхай шингэн
-  Шатамхай хийнүүд
-  Цахилгаан хүчдэл

ХӨӨСӨН ГАЛЫН ХОР

-  Мод даавуу, органик нэгдэл
-  Бензин, шатамхай шингэн
-  Цахилгаан хүчдэл болохгүй
-  Шатамхай хийнүүд болохгүй

УС, УСАН ГАЛЫН ХОР

-  Мод даавуу, органик нэгдэл
-  Цахилгаан хүчдэл болохгүй
-  Бензин, шатамхай шингэн болохгүй
-  Шатамхай хийнүүд болохгүй

CO₂ ХИЙН ГАЛЫН ХОР

-  Бензин, шатамхай шингэн
-  Цахилгаан хүчдэл
-  Мод даавуу, органик нэгдэл болохгүй
- 

“НАНО ИМПЕКС” ХХК ☎ 11455752; 80180101; 80440101 ✉ info@nanoimpex.mn 📍 БЗД, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө-12, (ХААЯ-ны ард) Гал төв 101 тоот

Зураг 5. Гал унтраах хэрэгсэл

Анхааруулах тэмдэгүүд



Цахилгааны тэмдэгтүүд



Хориглох тэмдэгүүд



Сануулах тэмдэгүүд



Зураг 6. Аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээ

4.2.6 Хог хаягдлын менежментийг төлөвлөгөө

Хог хаягдлын менежмент гэдэг нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлын эх үүсвэрийг бууруулах, ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах бүхий л процессыг хянаж сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ юм.

Эзэмшил газрынхаа ойр орчны цэвэрлэгээг тогтмол хийх, үйл ажиллагааны явцад үүсэх хог хаягдлыг тогтоосон цэгт хуримтлуулж тогтмол хугацаанд зайлуулах, ангилан ялгаж дахин ашиглах боломжтой хаягдлыг ашиглах, аливаа зүйлээр бохирдсон хог хаягдлыг саармагжуулах, галын аюулаас хамгаалах, хадгалалт хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэгч нь хог хаягдлын менежментийн хүрээнд цаашдын авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хог хаягдлыг газар дээр нь ангилан ялгах нөхцөл бололцоог хангаж ажиллах үүрэгтэй.

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хадгалахдаа хогийн сав болон хогийн цэгийг өнгөөр ялгаж зургаар тэмдэгжүүлснээр хуурай хог хаягдлыг стандартын дагуу ачиж, тээвэрлэх хадгалах нөхцөл бүрдэхээс гадна байгаль орчинд сөрөг нөлөөгүй бохирдолгүй амьдрах нөхцөл бололцоо бий болох юм.

Төслийн үйл ажиллагаанаас хатуу, шингэн хог хаягдал гарах ба тус бүрд нь тохирсон арга хэмжээг авч ажиллахдаа төслийн үйл ажиллагаанаас үүсэж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох хог хаягдал хэмжээг гэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах 4R зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай. Хог хаягдлын сөрөг нөлөөлөл болон түүний хэмжээг бууруулахад доорх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Эдгээрт:

Хог хаягдлын ангилал	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хамрах хүрээ	Зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
----------------------	-------------------------	--------------	------------------	--------------------------------	---------------------------------

Ахуйн	Хог хаягдлын менежментийг зохистой төлөвлөн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх буюу 4R зарчмыг баримтлан ажиллах / Refuse rethink-хэрэггүй худалдан авалт хийхээс татгалзах, Reduce-хаягдлаа багасгах, Reuse-дахин ашиглах, дахин боловсруулах, Recycle-дахин боловсруулах, Recovery rot-сэргээх, засах /	Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал	-	Төсөл хэрэгжих хугацаанд	- Хог хаягдлын тухай хууль - Ариун цэврийн тухай хууль - Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, - Хог хаягдлыг ангилан ялгаж хаях журам
	3 тасалгаат хогийн савыг байрлуулах	Төслийн гадна талбай	700.0	2025 онд	
Хатуу хот хаягдал	Уурхайн олборлолтын талбай болон ШТС-ын орчинд хийн хаягдал, хүдрийн тоос гарч агаар орчин бохирдож болзошгүй тул оффисын агааржуулалтын тоног төхөөрөмжийг тогтмол ажиллагаатай байлгах	Төслийн талбай, оффис	Дотоод төлөвлөлтөөр		
Шингэн хог хаягдал	Септик систем суурилуулах	Ажилдчын кемп, уурхайн тосгон орчимд	40,000.0	2025 он	- MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага
Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал			40,700.0 мян.төг		

Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хатуу хог хаягдалын менежмент:

Ахуйн хог хаягдал: Төслийн үйл ажиллагаанд өдөрт 120 хүн ажиллана. Ажилчдын ахуйн хог хаягдал, хэрэглээнээс гарсан бичгийн цаас, хоол хүнсний хаягдал, хүмүүсийн эдэлж, хэрэглэж байсан эд, гутал хувцасны уранхай, тасархай болон бусад эд зүйлс гарах тул ахуйн хэрэглээнээс гарч байгаа хатуу хог хаягдлыг зориулалтын тасалгаатай, тагтай саванд цуглуулж ТҮК-тай гэрээ байгуулсан гэрээний ачуулж байх хэрэгтэй.

Төсөл хэрэгжих хугацаанд “Литиум сенчури” ХХК-ийн MV-022910 тоот ашиглалтын тусгай зөвшрөөлтэй талбайд ажилчдын кемп байгуулахгүй гэж төлөвлөж байгаа. Иймд тухайн төслийн талбайд зөвхөн ахуйн бохир цэвэрлэх септик системийг зөвлөн менежментийн төлөвлөгөөнд тусгалаа.

4.2.7 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Хугацаа, давтамж	Зардал /мян.төг/	Хариуцах албан тушаалтан
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх, шинэчлэн засварлах	2025 он	Дотоод төлөвлөлтөөр	Төсөл хэрэгжүүлэгч
Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох байгаль орчны алба болон байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	2025 он	500.0	
Ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулж, хамруулах /Төслийн ажилтан тус бүрийг болзошгүй ослын үед ажиллах сургалтад хамруулж дадлагажуулах./	2025 он /4,9 сар/	1000.0	
Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг байгаль орчны газарт хүргэн өгч байх	Жил бүрийн 12 сард	300.0	
Байгаль хамгаалахад аймаг, сумын холбогдох ажилтнуудын оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-нд тусгах	2025 он	500.0	
Ариун цэвэр, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр сургалтыг системтэй зохион байгуулах	2025 он	Дотоод төлөвлөлтөөр	
Ослын үед болон шаардлагатай үед ажилчдад цаг алдалгүй эмнэлгийн анхны тусламж үзүүлэх анхны тусламжийн эмийн санг бэлдэх	2025 он	500,0	
Орон нутгийн засаг захиргаанаас зааж өгсөн талбайд 1-2 м өндөртэй мод, бут сөөгийн үрсэлгээ тарьж ногоон байгууламж байгуулах.	2025 он	1000.0	
Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал		3,800.0	

Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн хүрээнд хэрэгжүүлэх ажил

4.3 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Литиум сенчури” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Уртын цагаан чулуут литийн ордыг ил аргаар ашиглах” төслөөс байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан баримт бичиг юм.

ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан байх ба байгаль орчныг хамгаалах арга хэмжээний үр дүнг илэрхийлнэ. Мөн төслийн байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүд нь үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу төсөл батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 11 дугаар сарын 01-ний дотор БОУАӨЯ-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг төсөл хэрэгжүүлэгч хариуцах болно.

Энэхүү төслийг хэрэгжүүлэх явцад БОМТ-ний тайланд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.

ОХШХ нь байгаль орчин, нийгэм-эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа нь ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичиг болно.



Зураг 7. Төслийн талбай дахь мониторингийн цэг

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Зардал /мян.төг/	Нийт зардал (мян.төг)	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1. АГААРЫН ЧАНАР						
1.1	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэх	Мониторингийн цэг	Агаарын найрлага: жилд 4 удаа	300.0	жилд 4 Удаа * 5 цэг НИЙТ 6,000.0	- MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага - MNS 3113:1981 Агаар мандал. Агаарын бохирдуулах бодисыг тодорхойлох аргад тавигдах ерөнхий шаардлага
1.2	Ажлын байрны дотоод орчны агаарын шинжилгээ хийлгэх	Ажилчдын байр, лаборатори зэрэг ажлын байранд	Агаар дахь хорт бодис	300.0	жилд 4 удаа * 4 цэг НИЙТ 6,000.0	MNS 4990:2023 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь хорт бодисыг хэмжихэд тавих ерөнхий шаардлага, зөвшөөрөх дээд хэмжээ.
				12,000.0 мян.төг		
2. УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ						
2.1	Усны ерөнхий шинжилгээ	Унд ахуйн уснаас	Жилд 4 удаа	200.0*3 худаг	4 удаа НИЙТ 2,400.0	- MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж
2.2	Химийн шинжилгээ	Унд ахуйн уснаас	Жилд 4 удаа	200.0*3худаг	4удаа НИЙТ 2,400.0	- MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгэ
2.3	Микробиологийн шинжилгээ	Унд ахуйн уснаас	Жилд 4 удаа	200.0*3худаг	4удаа НИЙТ 2,400.0	- MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
2.4	Саарал ус	Ахуйн бохир цэвэрлэх байгууламжаас	Жил 2 удаа	200.0	2удаа НИЙТ 400.0	
				7,600.0 мян.төг		

3. ХӨРСНИЙ БОХИРДОЛ						
3.1	Хөрсний хими физик шинж чанар, шинжилгээг хийлгэх	Мониторингийн цэг, хог хаягдлын цэг	Жилд 4 удаа, 8 цэгт	50.0	жилд 4 удаа * 4 цэг НИЙТ 800.0	- MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага - MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга - MNS 7050:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
3.2	Хүнд металлын шинжилгээ хийлгэх	Ахуйн, шатах тослох материалын хог хаягдлын цэг, хаягдлын далан	Жилд 4 удаа, 4 цэг	200.0	4 удаа* 4 цэг НИЙТ 3,200.0	
	Нянгийн шинжилгээ хийлгэх	Мониторингийн 1 цэг, ахуйн бохир цэвэрлэх байгууламж орчим	Жилд 2 удаа 2 цэгт	200.0	4 удаа* 4 цэг НИЙТ 3,200.0	
				7,200.0 мян.төг		
Нийт ОХШ зардал				26,800.0		

Хүснэгт 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хуваарь

4.4 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоог тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог хууль тогтоомжид заасан хүрээнд аль болох өргөн хангах, тэдэнд ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилт болно.

Төсөл хэрэгжүүлэгч жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх мөн төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн хорооны иргэдийн нийтийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх хуваарийг доорх хүснэгтэнд үзүүлэв.

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов / он.сар/	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу БОУАӨЯ	Тайлан батлуулах	БОМТ	2025.6	-	БОУАӨЯ
Нийслэлийн байгаль орчны газар	Хэрэгжилтийг хянуулах	БОМТ	2025.11	-	НБОГ
Туул голын сав газрын захиргаа	Хэрэгжилтийг хянуулах	БОМТ	2025.11	-	Сав газрын захиргаа
Тухайн төсөл хэрэгжих бүс нутагт байгаа хүмүүс тайлагнах	Тайлангийн танилцуулга	БОМТ	2025.11	-	Төсөл хэрэгжүүлэгч
Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам	Хэрэгжилтийг тайлагнах	БОМТ	2025.11	-	БОУАӨЯ

Хүснэгт 14. БОМТ-ний биелэлтийн тайланг хэлэлцүүлэх хуваарь

ДҮГНЭЛТ

Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчноо хамгаалах, нийгмийн хариуцлагын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт 332 га талбайд “Литиум сенчури” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Уртын цагаан чулуут литийн ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал” болон ерөнхий үнэлгээний дүгнэлтийн дагуу боловсрууллаа.

Төслийн үйл ажиллагааны явцад БОМТ-д тусгагдсан төлөвлөгөөг дагаж мөрдөн төслийн үйл ажиллагаанаас гарах хатуу, шингэн хог хаягдлын байгальд орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчинд халгүй аргаар зайлуулах арга хэмжээг төлөвлөн ажиллах шаардлагатай.

Менежментийн зардлыг 1 жилийн хугацаанд хийгдэх ажилд 99,200 мян.төгрөгийн төсөвлөн төлөвлөгөө гаргасан бөгөөд тухайн төслийн буюу “Уртын цагаан чулуут литийн ордыг ил аргаар ашиглах” төслийн хүрээнд үйл ажиллагаа явуулах явцдаа дээрх менежментийн төлөвлөгөөний зардлаас илүү зардал гаргах боломжтой гэж үзэж байгаа бөгөөд тухайн зардлыг “Литиум сенчури” ХХК үйл ажиллагааны зардал болон байгууллагын дотоод зардлаар нөхөн зарцуулан гэж тооцлоо.

ХАВСРАЛТ

1. “Литиум сенчури” ХХК–ийн аж ахуй нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ
2. Уртын цагаан чулуут литийн ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл, /MV-022910 /
3. Кадастрын лавлагаа
4. Техник эдийн засгийн үндэслэл
5. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам ашигт малтмал, газрын тосны газар эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт
6. Үндэсний геологийн албаны даргын тушаал /Нөөцийг хүлээн авч, бүртгэх тухай/
7. Тойрох /Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх ЭМБЗ-ийн салбар хуралдаанаар засварлуулахаар шийдвэрлэсэн ТЭЗҮ/
8. Ой усан сан бүхий газартай давхцалтай эсэх лавлагаа
9. БОУАӨЯ-ны ерөнхий үнэлгээний дүгнэлт
10. Цэвэр ус худалдах гэрээ
11. Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт
12. Хөрсний задлан шинжилгээний дүн мэдээ
13. БОННҮ-ний мэргэжлийн байгууллагын УБ-ын гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн хуулбар